



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 598

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 67 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 147,687,252.00 (нэг зуун дөчин долоон сая зургаан зуун наян долоон мянга хоёр зуун тавин хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий хуучин барилгыг 5,900,000.00 (таван сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 295 м.кв талбай бүхий газрын эзэмших эрхийн хамт төрийн өмчид хүлээн авч, Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шинжилгээний албанд эзэмшүүлж, үндсэн хөрөнгө-биет бус хөрөнгөд тус тус бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Д.Ядамдорж, тогтоолд заасан харьяа байгууллагын дарга болон Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Дашпунцаг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006968

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны ... дугаар сарын ... ны өдрийн
598... дугаар тогтоолын хавсралт



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Конторын барилга, хуучин (Говь-Алтай аймаг, Есөн булаг сум, Оргил баг)	ш	1	147,687,252.00	8,440,720.00	139,246,532.00
2	Газар-газрын эрх (Говь-Алтай аймаг, Есөн булаг сум, Оргил баг)	м2	295	5,900,000.00		5,900,000.00
	Нийт дүн			153,587,252.00		145,146,532.00